



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 43 (472)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр бодох цалингийн ангилал, индексийг батлах тухай*

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

- *Цөмийн террорист үйлдлийг хориглох тухай олон улсын конвенц*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2006 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2006 оны арваннэгдүгээр сарын 21

№43 (472)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

641.	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр бодох цалингийн ангилал, индексийг батлах тухай	Дугаар 207	1253
642.	Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай	Дугаар 210	1256
643.	Ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай	Дугаар 213	1256
644.	Ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай	Дугаар 216	1256
645.	Ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай	Дугаар 217	1256
646.	Ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай	Дугаар 218	1257
647.	Ажилд томилох тухай	Дугаар 219	1257
648.	Ажилд томилох тухай	Дугаар 220	1257
649.	Журам батлах тухай	Дугаар 238	1257
650.	Аж ахуйн нэгж байгууллагын тооллогын дүнд үндэслэн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай	Дугаар 242	1259
651.	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 245	1259
652.	Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн цахилгаан шатны талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 247	1260

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

653.	Цөмийн террорист үйлдлийг хориглох тухай олон улсын конвенц		1260
------	---	--	------

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 8 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 207

Улаанбаатар хот

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр бодох цалингийн ангилал, индексийг батлах тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр бодох цалингийн ангилал, индексийг хавсралт ёсоор баталсугай.

2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр бодох цалингийн ангилал, индексийг баталсантай холбогдуулан дараахь арга хэмжээ авахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Л.Одончимэд, Сангийн сайд Н.Баяртсайхан нарт даалгасугай:

а/Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авч байгаа иргэдийн тэтгэврийн хэмжээг энэ тогтоолын хавсралтаар баталсан цалингийн

ангилал, индексээр шинэчлэн тогтоож 2006 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс тооцон олгох;

б/Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр бодох цалингийн ангилал, индексийг хэрэглэсэн боловч тэтгэвэр нь нэмэгдээгүй иргэдийн тэтгэврийн хэмжээг бууруулахгүй байх.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Итгэлцүүрийг шинэчлэн тогтоох, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" Засгийн газрын 2005 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 22 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН

ЕРӨНХИЙ САЙД

САНГИЙН САЙД

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,

ХӨДӨЛМӨРИЙН САЙД

М.ЭНХБОЛД

Н.БАЯРТСАЙХАН

Л.ОДОНЧИМЭД

Засгийн газрын 2006 оны 207 дугаар тогтоолын хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР БОДОХ ЦАЛИНГИЙН АНГИЛАЛ, ИНДЕКС

Д/э	1990 он		1991 он		1992 он		1993 он		1994 он		1995 он		1996 он		1997 он		1998 он	
	Цалингийн ангилал	Индекс	Цалингийн ангилал	Индекс	Цалингийн ангилал	Индекс	Цалингийн ангилал	Индекс	Цалингийн ангилал	Индекс	Цалингийн ангилал	Индекс	Цалингийн ангилал	Индекс	Цалингийн ангилал	Индекс	Цалингийн ангилал	Индекс
1	33С хуртал	235.15	600 хуртал	117.58	1180 хуртал	59.70	2660 хуртал	26.50	4450 хуртал	15.81	5500 хуртал	12.79	74410 хуртал	4.89	17300 хуртал	4.08	18570 хуртал	3.80
2	301-250	219.08	601-700	109.37	1181-1470	52.38	2481-2930	26.19	4451-4960	15.47	5501-6150	12.48	144111-15790	4.87	17201-18950	4.06	18571-20360	3.78
3	351-410	209.73	701-820	104.99	1471-1660	51.93	2931-3350	25.70	4961-5800	14.85	6151-6950	12.40	15791-17720	4.86	18951-21280	4.05	20361-22880	3.77
4	411-500	207.42	821-1000	103.92	1661-2070	50.15	3351-4160	24.91	5901-7200	14.37	6951-8420	12.32	17731-21380	4.85	21281-25600	4.04	22881-27580	3.76
5	501-560	205.14	1001-1100	102.57	2071-2300	49.05	4161-4600	24.53	7201-8050	14.02	8421-9250	12.20	21381-23310	4.84	25661-27970	4.03	27581-30070	3.75
6	561-650	184.40	1101-1300	92.20	2301-2520	47.56	4601-5220	22.96	8051-8900	13.47	9251-9860	12.15	23311-24810	4.83	27971-29780	4.02	30071-32010	3.74
7	651-750	174.38	1301-1500	87.19	2521-2830	46.21	5221-6060	21.58	8901-10200	12.82	9861-11570	11.29	24811-27130	4.82	29781-32560	4.01	32011-35000	3.73
8	751-850	161.15	1501-1700	80.57	2831-2980	46.00	6061-6860	19.94	10201-11200	12.23	11571-12300	11.14	27131-28530	4.80	32561-34240	4.00	35001-36810	3.72
9	851-950	145.32	1701-1900	72.66	2981-3100	44.50	6861-7870	17.99	11201-11970	11.52	12301-13010	10.60	28531-29370	4.70	34241-35250	3.92	36811-37890	3.64
10	951-1100	126.86	1901-2200	63.40	3101-3200	43.93	7871-9290	15.09	11971-13110	10.89	13011-13890	10.09	29371-30140	4.65	35251-36180	3.88	37891-38890	3.60
11	1101-1200	122.19	2201-2400	61.12	3201-3260	43.58	9291-10100	14.63	13111-13970	10.57	13891-14680	10.06	30141-32110	4.60	36181-38540	3.83	38891-41690	3.54
12	1201-1330	119.19	2401-2660	59.62	3391-3690	43.00	10101-10900	14.58	13971-15200	10.46	14681-16300	9.75	32111-35080	4.53	38541-42100	3.78	41691-46220	3.44
13	1331-1500	117.41	2661-3000	58.70	3691-4050	42.41	10901-12100	14.19	15201-16590	10.34	16301-17750	9.64	35081-38270	4.49	42101-45920	3.74	46221-50080	3.29
14	1501-6а туунаас баш	110.00	3001-6а туунаас баш	55.00	4051-6а туунаас баш	39.80	12101-6а туунаас баш	13.00	16591-6а туунаас баш	9.70	17751-6а туунаас баш	9.05	38271-6а туунаас баш	4.21	45921-6а туунаас баш	3.50	50081-6а туунаас баш	3.18

Д/У	1999 он		2000 он		2001 он		2002 он		2003 он		2004 он		2005 он		2006 он	
	Цэвэрлэлт авчирал	Индэс	Цэвэрлэлт авчирал	Индэс	Цэвэрлэлт авчирал	Индэс	Цэвэрлэлт авчирал	Индэс	Цэвэрлэлт авчирал	Индэс	Цэвэрлэлт авчирал	Индэс	Цэвэрлэлт авчирал	Индэс	Цэвэрлэлт авчирал	Индэс
1	19000	3.71	26780	2.63	28160	2.50	33900	2.08	42370	1.66	47000	1.50	70600	1.00	70600	1.00
2	19007	3.69	26781-	2.58	28161-	2.46	33901-	2.04	42371-	1.55	47031-	1.44	70601-	1.00	70601-	1.00
3	20871-	3.68	29741-	2.57	31291-	2.45	37691-	2.03	46711-	1.53	53441-	1.43	76891-	1.00	76891-	1.00
4	23451-	3.67	33401-	2.56	35151-	2.44	42391-	2.02	51291-	1.52	59941-	1.42	86191-	1.00	86191-	1.00
5	28271-	3.66	40381-	2.55	42501-	2.41	51291-	2.00	56450	1.51	73411-	1.41	103701-	1.00	103701-	1.00
6	30821-	3.65	44101-	2.54	46881-	2.40	56450	1.99	60320	1.49	80290	1.38	112820	1.00	112820	1.00
7	32811-	3.64	47181-	2.49	49831-	2.34	60321-	1.96	66800	1.41	80681-	1.31	119860	1.00	119860	1.00
8	35871-	3.57	52451-	2.46	55661-	2.31	66800	1.93	70860	1.39	99991-	1.30	136970	1.00	136970	1.00
9	38401-	3.40	56801-	2.43	59731-	2.20	70861-	1.84	79861-	1.37	105601-	1.28	136971-	1.00	136971-	1.00
10	40651-	3.23	61770	2.07	62801-	1.80	75101-	1.57	80350	1.36	108231-	1.26	138000	1.00	138000	1.00
11	43391-	3.22	67771-	2.06	77801-	1.74	89351-	1.51	97790	1.28	110841-	1.20	140170	1.00	140170	1.00
12	45891-	3.13	71801-	2.00	84751-	1.68	97791-	1.45	109450	1.24	137460	1.16	158990	1.00	158990	1.00
13	50861-	3.06	76651-	1.74	94361-	1.63	109451-	1.40	122600	1.22	151220	1.14	171650	1.00	171650	1.00
14	56161 ба түүрхэс дээр	2.86	90471 ба түүрхэс дээр	1.63	105501 ба түүрхэс дээр	1.52	122601 ба түүрхэс дээр	1.36	140670 ба түүрхэс дээр	1.14	151221 ба түүрхэс дээр	1.10	171651 ба түүрхэс дээр	1.00	171651 ба түүрхэс дээр	1.00

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр

Дугаар 210

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь: "Шинжлэх ухааны талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1997 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын шинжлэх ухааны байгууллагуудын бүтцийн өөрчлөлт хийх чиглэл"-ийн "А.Улсын эрдэм шинжилгээний хүрээлэн, төвүүд" гэсэн хэсгийн 17 дугаар заалтад "Өндөр уулын бүсийн хөдөө аж ахуйн эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн станц"

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

гэсний дараа "Төв аймгийн Батсүмбэр суман дахь Зөгийн аж ахуйн эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн станц" гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД Ө.ЭНХТҮВШИН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр

Дугаар 213

Улаанбаатар хот

Засгийн газрын тухай хуулийн 18¹ дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Гаалийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 17.12-ыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хорлоогийн Баатарыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Улсын гаалийн ерөнхий газрын даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай

2. Баагаагийн Баттөмөрийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Улсын гаалийн ерөнхий газрын даргаар түр томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

САНГИЙН САЙД Н.БАЯРТСАЙХАН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр

Дугаар 216

Улаанбаатар хот

Засгийн газрын тухай хуулийн 18¹ дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Данзангийн Сандаг-Очирыг Засгийн газрын тохируулагч агентлаг-Цагдаагийн ерөнхий газрын даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай

2. Маньбадрахын Ганболдыг Засгийн газрын тохируулагч агентлаг-Цагдаагийн ерөнхий газрын даргаар томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД Д.ОДБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр

Дугаар 217

Улаанбаатар хот

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 17.12-ыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Янсанжавын Адъяаг Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай

2. Дэлэгийн Загджавыг Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн даргаар түр томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

БАЙГАЛЬ ОРЧНЫ
САЙД И.ЭРДЭНЭБААТАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр

Дугаар 218

Улаанбаатар хот

Ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18^д дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 6.1.2, Төрийн албаны тухай хуулийн 17.12-ыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2. Санжаажавын Батмөнхийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Иргэний нисэхийн ерөнхий газрын даргаар түр томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

М.ЭНХБОЛД

1. Манжийн Дагвыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

**ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Ц.ЦЭНГЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр

Дугаар 219

Улаанбаатар хот

Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18^д дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 45 дугаар зүйлийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

хэмжил зүйн төвийн даргаар томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

М.ЭНХБОЛД

Галбадрахын Гантөмөрийг Засгийн газрын тохируулагч агентлаг-Стандартчилал,

**МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД**

М.ЭНХСАЙХАН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр

Дугаар 220

Улаанбаатар хот

Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18^д дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Гаалийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 17.12-ыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

гаалийн ерөнхий газрын дэд даргаар түр томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

М.ЭНХБОЛД

Нанзадын Чулуунбаатарыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Улсын

САНГИЙН САЙД

Н.БАЯРТСАЙХАН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 10 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 238

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хуулийн 16.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

байгууллага, иргэдэд тайлбарлан танилцуулах, түүний хэрэгжилтэд байнга хяналт тавьж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

1. "Аюултай хог хаягдлыг паспортжуулах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРАНХИЙ САЙД**

М.ЭНХБОЛД

2. Аюултай хог хаягдлыг паспортжуулах журмыг тухайн нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж,

**БАЙГАЛЬ ОРЧНЫ
САЙД**

И.ЭРДЭНЭБААТАР

Засгийн газрын 2006 оны 238 дугаар тогтоолын хэсэрлэлт

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ПАСПОРТЖУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Аюултай хог хаягдлыг паспортжуулахад энэ журмыг дагаж мөрдөнө.

1.2. Аюултай хог хаягдлын паспорт нь /црашид "паспорт" гэх/ тухайн хог хаягдлын бүтцийн талаархи мэдээллийг агуулсан, ямар төрөл аюулын зэрэглэлтэй хог хаягдалд хамаарахыг тогтоосон, тэдгээрийг ашиглах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, булах, устгах технологийг тусгасан баримт бичиг мөн.

1.3. Паспорт нь эх үүсвэрээс гарах аюул, эрсдэлийн талаархи мэдээллийг ил тод болгох, аюултай хог хаягдлын хор хөнөөлөөс сэргийлж, хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах үүргийг тухайн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд хариуцуулахад оршино.

1.4. Аюултай хог хаягдал гаргадаг, түүнтэй харьцдаг аж ахуйн нэгж, байгууллага, иргэн заавал паспорт авна.

1.5. Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай хуулийн 3.3-т заасан аюултай хог хаягдлын ангилалд тодорхойлогдсон хог хаягдлаас гарч болох осол, эрсдэлийн тухай мэдээллийг хэрэглэгчдэд хүргэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг тухайн аюултай хог хаягдал гаргагч аж ахуйн нэгж, байгууллага, иргэн хариуцна.

Хоёр. Аюултай хог хаягдлын паспорт авах

2.1. Аюултай хог хаягдал гаргадаг, түүнтэй харьцдаг аж ахуйн нэгж, байгууллага, иргэн тухайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө паспорт олгохыг хүссэн хүсэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ. Уг хүсэлтэд дараахь мэдээллийг хавсаргасан байна:

2.1.1. эх үүсвэр болон хог хаягдал гаргагч, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нэр, хаяг;

2.1.2. тухайн төрлийн хог хаягдалд агуулагдаж байгаа хортой, аюултай бодисын агууламжийн хэмжээ, хоруу чанар, аюул эрсдэлийн тухай мэдээлэл;

2.1.3. хог хаягдлын биологийн болон физик-химийн шинж чанар;

2.1.4. аюултай хог хаягдал гаргах, ашиглах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, булах, устгах явцад хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл;

2.1.5. энэ журмын 2.1.4-т зааснаас үүдэлтэй аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах чадвар бүхий мэргэжилтэй боловсон хүчин, энэ ажилд зориулагдсан тоноглол хэрэгслийн нөөц хангамж;

2.1.6. аюултай хог хаягдлыг ашиглах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, булах, устгах үед аюул, осол гарсан тохиолдолд үзүүлэх анхан шатны тусламж, хор уршгийг арилгахад шаардагдах бэлтгэл нөөцийн бүрдэл, аригалт.

2.2. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн аюултай хог хаягдлынхаа тухай мэдээллийг үнэн зөвөөр гаргах үүрэгтэй.

Гурав. Аюултай хог хаягдлын паспорт олгох

3.1. Энэ журмын 2.1-д заасан шаардлагыг хангасан аж ахуйн нэгж байгууллага, иргэнд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага паспорт олгоно. Паспортын загварыг байгаль орчны асуудал эрхэлсэн сайд батална. Паспорт нь нууцлалтай байна.

3.2. Аюултай хог хаягдлын бүтцийн талаархи мэдээллийг бүрэн эзэмшсэн, тэдгээрийг тээвэрлэх, хадгалах, булах, устгах технологийн шаардлага хангасан, мэргэжлийн боловсон хүчин бүхий аж ахуйн нэгж, байгууллага болон энэ чиглэлийн боловсрол, мэргэшилтэй иргэнд паспортыг олгоно.

3.3. Аюултай хог хаягдлын паспортгүй аж ахуйн нэгж, байгууллага, иргэн тухайн хог хаягдлыг ашиглах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, булах, устгах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

3.4. Аюултай хог хаягдлын паспорт нь олгосон өдрөөсөө эхлэн гурван жил хүртэл хугацаанд хүчинтэй байх бөгөөд түүнийг зөвхөн нэг удаа хоёр хүртэл жилээр сунгана.

3.5. Аюултай хог хаягдалтай харьцах технологийн шаардлагыг зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний паспорт эзэмших эрхийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр цуцална.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 10 дугаар сарын 11-ний өдөр

Дугаар 242

Улаанбаатар хот

Аж ахуйн нэгж, байгууллагын тооллогын дүнд үндэслэн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Аж ахуйн нэгж, байгууллагын 2006 оны тооллогын явцад улсын бүртгэлд бүртгүүлсэн аж ахуйн нэгжүүдээс үйл ажиллагаагаа зогсоосон, хаяг, байршил нь тодорхойгүй, үйл ажиллагаа явуулаагүй аж ахуйн нэгж олноор илэрсэн байдлыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын хэмжээнд баримтлах кодын нэгдсэн системийг бүрдүүлэх, олон улсад нийтлэг мөрдөхөөр зөвлөмж болгосон ангиллуудад үндэслэн боловсруулсан үндэсний ангилал, нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгжид ашиглагдаж байгаа код аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн дугаарыг 2007 оны I улирлаас эхлэн улсын хэмжээнд нэгдсэн байдлаар мөрдүүлэх арга хэмжээг Үндэсний статистикийн газар, Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газартай хамтран авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд Н.Баяртсайханд үүрэг болгосугай.

2. Хуулийн этгээдийн бүртгэлийг улсын хэмжээнд нэгдсэн системд оруулах асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулан Засгийн газрын хуралдаанд оруулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаярт даалгасугай.

3. Аж ахуйн нэгж, байгууллагын тооллогын үр дүнгийн тайланг хэвлэн хэрэглэгчдэд тараахад

шаардагдах 8.0 /найман/ сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд Н.Баяртсайханд зөвшөөрсүгэй.

4. Үндэсний статистикийн газар /П.БЯМБАЦЭРЭН/-т зөвлөх нь:

а/ улсын хэмжээнд тооллого, судалгаа явуулах ажлыг мэргэжлийн байгууллагын зүгээс нийтлэг аргачлалаар хангаж, үр дүнд нь хяналт тавих механизмыг бий болгон 2007 оны 1 дүгээр сараас эхлэн мөрдүүлсүгэй;

б/ аж ахуйн нэгж, байгууллагын тооллогын үр дүнгээр дэлгэрэнгүй тайлан болтгаж, хэрэглэгчдэд тараах ажлыг энэ оны 10 дугаар сард багтаан зохион байгуулсугай;

в/ аж ахуйн нэгж, байгууллагын тооллогын дүнд үндэслэн бизнес регистрийн нэгдсэн санг шинэчлэх, аж ахуйн нэгж, байгууллагын талаархи мэдээллээр хэрэглэгчдийг хангаж ажиллах бие даасан нэгжийг 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр Үндэсний статистикийн газарт байгуулан ажиллуулж холбогдох зардлыг нь төсөвт тусгах.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 10 дугаар сарын 11-ний өдөр

Дугаар 245

Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

үндэсний хороо" гэснийг "Худалдаа, тээврийг хөнгөвчлөх Үндэсний хороо" гэж өөрчилсүгэй.

"Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2005 оны 66 дугаар тогтоолын 17 дугаар хавсралтын 34-т "Дамжин өнгөрөх тээврийн асуудлыг зохицуулах

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Ц.ЦЭНГЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 10 дугаар сарын 11-ний өдөр

Дугаар 247

Улаанбаатар хот

Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн цахилгаан шатны талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ НЬ:

1. Дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Ж.Наранцацралт, Сангийн сайд Н.Баяртсайхан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Ц.Батбаяр, Орхон, Дархан-Уул аймгийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгож, Сууц өмчлөгчдийн холбоодын Дээд зөвлөл /Б.Жигжид/-д зөвлөсүгэй:

а/ нийтийн зориулалттай орон сууцны байшингийн ашиглалтын хугацаа нь дуусч ашиглах

боломжгүй болсон 239 цахилгаан шатыг шинэчлэхэд шаардагдах хөрөнгийн 30.0 хувийг улсын төсвөөс, 40.0 хувийг орон нутгийн төсвөөс, 30.0 хувийг сууц өмчлөгчдийн холбооноос тус тус санхүүжүүлэх арга хэмжээ авах;

б/ Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 16.6-д заасны дагуу улсын төсвийн хөрөнгөөр тухайн орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгөд өмнө нь засвар, шинэчлэлт хийж байгаагүй бол цахилгаан шатыг дор дурдсан хувиарийн дагуу шинэчлэх ажлыг зохион байгуулах.

Цахилгаан шат шинэчлэх газар	Хугацаа/оноор/	Тоо /ширхэг/
Улаанбаатар хот	2007	45
Улаанбаатар хот	2008	55
Улаанбаатар хот	2009	55
Улаанбаатар хот	2010	54
Орхон аймгийн төв	2008-2010	15
Дархан-Уул аймгийн төв	2008-2010	15

2. Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн цахилгаан шатны ашиглалт, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын чадавхийг бэхжүүлэх, мэргэжлийн ажилчдыг сургаж бэлтгэх, тэдгээрийг тогтвор суурьшилтай ажиллуулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Ж.Наранцацралт, нийслэл, холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгаж, Сууц өмчлөгчдийн холбоодын Дээд зөвлөл /Б.Жигжид/-д зөвлөн,

цахилгаан шатны ашиглалт, техникийн аюулгүй байдалд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд У.Хүрэлсүхэд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙД

Ж.НАРАНЦАЦРАЛТ

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

ЦӨМИЙН ТЕРРОРИСТ ҮЙЛДЛИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ*

Энэхүү конвенцид оролцогч улсууд,

олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахих болон улс хоорондын сайн хөршийн холбоо, найрсаг харилцаа, хамтын ажиллагааг дэмжин хөгжүүлэх талаархи Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн зорилго, зарчмыг санаж,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын 50 жилийн ойг тохиолдуулан 1995 оны 10 дугаар сарын 24-ний өдөр гаргасан тунхаглалыг эргэн санаж,

цөмийн эрчим хүчийг энх тайвны зорилгоор хөгжүүлж, хэрэглэх бүх улсын эрх болон цөмийн

эрчим хүчийг энх тайвны зорилгоор хэрэглэснээс үүсч болох үр ашгийг хүртэх тэдний хууль ёсны сонирхлыг хүлээн зөвшөөрч,

Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцийг анхзаралдаа авч,

терроризмын үйлдэл бүх хэлбэр, илрэлээрээ дэлхий дахинд өргөжиж байгааг сэтгэл гүнээ зовниж,

терроризмын бүх үйлдэл, арга, дадал, түүний дотор улс, эрд түмэн хоорондын найрсаг

* "Конвенц соёрхон батлах тухай" Монгол Улсын хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2006 оны 26 дугаарт нийтлэгдсэн.

харилцаанд занал учруулж, улсуудын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, аюулгүй байдалд заналхийлэх үйлдэл, арга, дадлыг хаана, хэн үйлдсэнээс нь үл хамааран гэмт бөгөөд зөвтгөх боломжгүй гэж шууд буруутгаж буйгаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн улсууд *inter alia* ёслол төгөлдөр дахин нотлосон Ерөнхий Ассамблейн 1994 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 49/60 тоот тогтоолд хавсаргасан Олон улсын терроризмыг арилгах арга хэмжээний тухай тунхаглалыг мөн эргэн санаж,

асуудлын бүх талыг хамарсан эрх зүйн иж бүрэн хүрээ бий болгож зорилгоор терроризмоос бүх хэлбэр, илрэлээр нь урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох, арилгах талаархи одоо үйлчилж буй олон улсын эрх зүйн заалтуудыг улсууд яаралтай хянан үзэхийг уг тунхаглал хөхиүлэн дэмжсэнийг тэмдэглэж,

Ерөнхий Ассамблейн 1996 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 51/210 тоот тогтоол болон түүний хавсралт болох Олон улсын терроризмыг арилгах арга хэмжээний тухай 1994 оны тунхаглалын нэмэлт тунхаглалыг эргэн санаж,

Ерөнхий Ассамблейн 51/210 тоот тогтоолын дагуу олон улсын одоо үйлчилж буй холбогдох баримт бичгүүдэд нэмэлт болгохоор Цөмийн террорист үйлдлийг хориглох тухай олон улсын конвенцийг *inter alia* болговсруулахаар *ad hoc* хороо байгуулагдсаныг мөн эргэн санаж,

цөмийн террорист үйлдэл нь хамгийн ноцтой үр дагаварт хүргэж болох болон олон улсын энх тайван, аюулгүй байдалд заналхийлэл учруулж болохыг тэмдэглэж,

олон улсын эрх зүйн одоо үйлчилж буй заалтууд тэдгээр халдлагыг хангалттай тусгаагүй байгааг мөн тэмдэглэж,

террорист ийм үйлдлээс урьдчилан сэргийлэх болон буруутай этгээдийг мөрдөх болон шийтгэх үр дүнтэй бөгөөд бодитой арга хэмжээ боловсруулж, батлах талаар улс хоорондын олон улсын хамтын ажиллагааг улам хөгжүүлэх яаралтай хэрэгцээ байгаа гэдэгт *итгэл төгс байж*,

улсуудын цэргийн хүчний үйл ажиллагааг энэхүү конвенцийн хүрээнээс гадуур олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулж байгаа бөгөөд энэхүү конвенцийн хамрах хүрээнээс тодорхой үйлдлүүдийг гаргасан нь хууль бус үйлдэл болох үйлдлийг хүлээн зөвшөөрч буюу хууль ёсны гэж өөрөөр үзэж буй хэрэг биш буюу өөр хуулийн дагуу мөрдөхөд саад болж буй хэрэг биш гэдгийг тэмдэглэж,

дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

1 дүгээр зүйл

Энэхүү конвенцийн зорилгод:

1. "Цацраг идэвхт материал" гэж өөрөө задардаг (альфа, бета-, нейтрон хэсэг болон гамма туяа зэрэг нэг буюу хэд хэдэн төрлийн ионжуулагч цацраг ялгаруулахын хамт явагддаг) бөгөөд цацрагт шинж, эсхүл хуваагдах шинжээрээ үхэлд хүргэх, бие махбодид хүнд гэмтэл учруулах, эсхүл өмч буюу хүрээлэн буй орчинд үлэмж хохирол учруулж болох нуклид агуулсан цөмийн материал болон цацраг идэвхт бусад бодисыг хэлнэ.

2. "Цөмийн материал" гэж 80 хувиас илүү плутони-238-ийн изотоп агуулснаас бусад плутони; уран-233, 235 буюу 233-изотопоор баяжуулсан уран; хүдэр буюу хүдрийн үлдэгдлээс бусад хэлбэрээр байгальд байдаг изотопын холимог агуулсан уран; эсхүл дээр заасан элементийн аль нэгийг буюу хэд хэдгийг агуулсан аливаа материалыг хэлнэ;

Мөн "235 буюу 233-изотопоор баяжуулсан уран" гэж эдгээр изотопын нийлбэрийн илүүдлийн 238-изотоптой харьцах харьцаа нь 235-изотопын 238-изотопод харьцах байгальд тохиолдох харьцаанаас илүү хэмжээгээр 235 буюу 233-изотопыг, эсхүл хоёуланг нь агуулсан ураныг хэлнэ.

3. "Цөмийн объект" гэж:

(a) Аливаа цөмийн хөдөлгүүр, түүний дотор усан онгоц, тээврийн хэрэгсэл, хөлөг онгоц буюу сансрын объектыг хөдөлгөөнд оруулахын тулд эрчим хүчний эх үүсвэрийн хувьд ашиглах зорилгоор, эсхүл аливаа өөр зорилгоор тэдгээр усан онгоц, тээврийн хэрэгсэл, хөлөг онгоц буюу сансрын объектод суулгасан хөдөлгүүр;

(b) Цацраг идэвхт материал үйлдвэрлэх, хадгалах, боловсруулах буюу тээвэрлэхэд ашиглаж буй аливаа байгууламж, эсхүл тээврийн хэрэгслийг хэлнэ.

4. "Төхөөрөмж" гэж:

(a) Аливаа цөмийн дэлбэрэх төхөөрөмж; эсхүл

(b) цацрагт шинжээрээ үхэлд хүргэх, бие махбодид хүнд гэмтэл учруулах, эсхүл өмч буюу хүрээлэн буй орчинд үлэмж хохирол учруулж болох цацраг идэвхт материал тархаач буюу цацраг ялгаруулах аливаа төхөөрөмжийг хэлнэ.

5. "Төрийн болон засгийн газрын объект" гэдэгт төрийн төлөөлөгч, засгийн газрын гишүүн, хууль тогтоох буюу шүүхийн байгууллага, эсхүл төрийн буюу улсын бусад аливаа байгууллагын албан тушаалтан буюу ажилтан, эсхүл засгийн газар



хоорондын байгууллагын ажилтан буюу албан тушаалтны албан үүрэгтэйгээ холбогдуулан байнга болон түр хугацаагаар ашиглаж буюу эзэмшиж буй аливаа объект, тээврийн хэрэгсэл хамаарна.

6. "Улсын цэргийн хүчин" гэж аль нэг улсын үндэсний батлан ​​хамгаалах, аюулгүй байдлыг хангах нэн тэргүүний зорилгоор дотоодын хуулийнх нь дагуу зохион байгуулагдаж, бэлтгэгдэж, тоноглогдсон зэвсэгт хүчин, түүнчлэн тэдгээрийн удирдлага, хяналт, хариуцлагын дор тэдгээр зэвсэгт хүчнийг дэмжих үүрэг гүйцэтгэгч этгээдүүдийг хэлнэ.

2 дугаар зүйл

1. Аливаа этгээд дараахь үйлдлийг хууль бусаар болон санаатайгаар хийсэн бол түүнийг энэхүү конвенцийн агуулгын хүрээнд гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ:

(a) цацраг идэвхт материал эзэмших, эсхүл төхөөрөмжийг дараахь хэлбэрээр санаатайгаар бэлтгэх буюу эзэмших:

(i) үхэлд хүргэх буюу бие махбодид хүнд гэмтэл учруулах; эсхүл;

(ii) өмч буюу хүрээлэн буй орчинд үлэмж хохирол учруулах;

(b) цацраг идэвхт материал буюу төхөөрөмжийг аливаа хэлбэрээр ашиглах, эсхүл цацраг идэвхт материал задруулах буюу задруулах эрсдэлтэй хэлбэрээр цөмийн объектыг дараахь хэлбэрээр санаатайгаар ашиглах буюу гэмтээх:

(i) үхэлд хүргэх буюу хүний ​​бие махбодид хүнд гэмтэл учруулах;

(ii) өмч буюу хүрээлэн буй орчинд үлэмж хохирол учруулах;

(iii) аливаа үйлдэл хийх буюу түүнээс түдгэлзэхийг хувь хүн болон хуулийн этгээд, олон улсын байгууллага буюу улсад тулгах.

2. Аливаа этгээд дараахь үйлдлийг хийсэн бол түүнийг мөн гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ:

(a) энэ зүйлийн 1 дэх хэсгийн (b) дэд хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэхээр заналхийлэх, чингэхдээ уг заналхийлэл нь бодитой гэдгийг харуулах нөхцөл байдал байгаа;

(b) заналхийлэх, чингэхдээ уг заналхийлэл нь бодитой гэдгийг харуулах нөхцөл байдал байгаа, эсхүл хүч хэрэглэх замаар цацраг идэвхт материал,

төхөөрөмж буюу цөмийн объектыг хууль бусаар болон санаатайгаар шаардах.

3. Аливаа этгээд 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдэхийг завдсан бол тухайн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэж мөн үзнэ.

4. Аливаа этгээд дараахь үйлдлийг хийсэн бол түүнийг гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ:

(a) энэ зүйлийн 1, 2 буюу 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт хамтран оролцсон; эсхүл

(b) энэ зүйлийн 1, 2 буюу 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг үйлдэх зорилгоор бусдыг зохион байгуулсан буюу удирдсан; эсхүл

(c) энэ зүйлийн 1, 2 буюу 3 дахь хэсэгт заасан нэг буюу хэд хэдэн гэмт хэргийг нэг зорилготойгоор үйл ажиллагаа явуулж буй бүлэг этгээд үйлдэхэд аливаа өөр хэлбэрээр хувь нэмэр оруулсан; чингэхдээ санаатайгаар бөгөөд уг бүлгийн ерөнхий гэмт үйл ажиллагаа буюу зорилгыг цааш нь дэмжих зорилгоор, эсхүл тухайн бүлгийн уг гэмт хэрэг буюу гэмт хэргүүдийг үйлдэх чиг санааг мэдсээр байж хувь нэмрээ оруулсан.

3 дугаар зүйл

Энэхүү конвенцийг гэмт хэргийг нэг улсын дотор үйлдсэн сэжигтэн этгээд болон хохирогчид нь тухайн улсын харьяат, сэжигтэн этгээд тухайн улсын нутаг дэвсгэрт олдсон, түүнчлэн аливаа өөр улс зохих үед 7, 12, 14, 15, 16 болон 17 дугаар зүйлийн заалтыг тухайн тохиолдолд хэрэглэхээс бусад үед 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, эсхүл 2 дахь хэсгийн дагуу хэргийн харьяаллаа хэрэгжүүлэх үндэслэл байхгүй бол хэрэглэхгүй.

4 дүгээр зүйл

1. Энэхүү конвенцийн аль ч заалт бусад улсын болон хувь хүний ​​олон улсын эрх зүй, ялангуяа Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн зорилго, зарчим болон олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн дагуу эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг хөндөхгүй.

2. Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйгээр зохицуулагддаг бөгөөд уг эрх зүйд ойлгогддог нэр томъёогоороо зэвсэгт мөргөлдөөний үед явагдаж буй зэвсэгт хүчний үйл ажиллагаа нь энэхүү конвенцоор зохицуулагдахгүй, түүнчлэн албан үүргээ хэрэгжүүлэх зорилгоор аль нэг улсын цэргийн хүчний явуулж буй үйл ажиллагаа нь олон улсын эрх зүйн өөр хэм хэмжээгээр зохицуулагддаг тул энэхүү конвенцоор зохицуулагдахгүй.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг хууль бус үйлдэл болох үйлдлийг хүлээн зөвшөөрөх буюу хууль ёсны гэж өөрөөр үзэж буй, эсхүл өөр хуулийн дагуу мөрдөхөд саад болж буй гэж тайлбарлахгүй.

4. Энэхүү конвенц нь улсуудын цөмийн зэвсэг хэрэглэх буюу хэрэглэхээр заналхийлэхийг хууль ёсны гэж үзэх эсэх асуудлыг хөндөхгүй бөгөөд аливаа хэлбэрээр хөндөж буй гэж тайлбарлагдахгүй.

5 дугаар зүйл

Оролцогч улс бүр дараахь чиглэлээр шаардлагатай байж болох арга хэмжээ авна:

(а) энэхүү конвенцийн 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийг дотоодын хуульдаа эрүүгийн гэмт хэрэг гэж тооцох;

(б) тэдгээр гэмт хэргийн ноцтой шинжийг харгалзан тохирох ял шийтгэлийг тогтоох.

6 дугаар зүйл

Оролцогч улс бүр энэхүү конвенцийн хүрээнд хамаарах гэмт хэрэг, ялангуяа олон нийт, бүлэг этгээд, эсхүл тодорхой этгээдүүдийн дунд терроризмын байдал үүсгэх зорилготой, эсхүл тийнхүү тооцоолсон гэмт хэргийг улс төр, гүн ухаан, үзэл суртал, арьс үндэс, үндэс угсаа, шашин шүтлэг, эсхүл адилтгах өөр үзлээр ямар ч нөхцөлд зөвтгөхгүй бөгөөд ноцтой шинжид нь тохирсон ялыг тэдгээрт оногдуулах явдлыг хангах талаар шаардлагатай байж болох арга хэмжээ авах, түүний дотор зохих үед дотоодын хууль тогтоомж батлана.

7 дугаар зүйл

1. Оролцогч улсууд дараахь хэлбэрээр хамтран ажиллана:

(а) 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийг нутаг дэвсгэрт нь, эсхүл нутаг дэвсгэрээс нь гадна үйлдэхээр тус тусын нутаг дэвсгэрт хийж буй бэлтгэлээс урьдчилан сэргийлэх болон түүний эсрэг сөрөг арга хэмжээ авах зорилгоор боломжтой бүх арга хэмжээ, түүний дотор шаардлагатай бол дотоодын хуулиа нийцүүлэх, ялангуяа тэдгээр гэмт хэргийг үйлдэхийг өөгшүүлэн дэмжих, өдөөн хатгах, зохион байгуулах, мэдсээр байж санхүүжүүлэх, эсхүл мэдсээр байж техникийн тусалцаа үзүүлэх буюу мэдээллээр хангах, эсхүл оролцож буй этгээд, бүлэг болон байгууллагын хууль бус үйл ажиллагааг өөрийн нутаг дэвсгэрт хориглох арга хэмжээ авах;

(б) дотоодын хуульдаа нийцүүлэн, түүнчлэн энд заасан нөхцлийн хэлбэрээр тэдгээр

нөхцлийн дагуу үнэн зөв, баталгаатай мэдээлэл солилцох, мөн 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, хориглох, мөрдөн байцаахаар, түүнчлэн тэдгээр гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэгдэж байгаа этгээдүүдийн эсрэг эрүүгийн хэрэг үүсгэхийн тулд шаардлагатай үед авах захиргааны болон бусад арга хэмжээг уялдуулан зохицуулах. Ялангуяа, аль нэг оролцогч улс 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийг үйлдсэн тухай болон тийм гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгааг мэдсэн бол 9 дүгээр зүйлд дурдсан бусад улсад сааталгүйгээр мэдээлэх, түүнчлэн зохих үед олон улсын байгууллагад мэдээлэхийн тулд зохих арга хэмжээ авна.

2. Оролцогч улсууд энэхүү конвенцийн заалтын дагуу оролцогч өөр улсаас нууцын зэрэглэлтэй авч байгаа, эсхүл энэхүү конвенцийг хэрэгжүүлэхээр явуулж буй үйл ажиллагаанд оролцон нууцын зэрэглэлтэй авч байгаа аливаа мэдээллийн нууцлалыг хамгаалах талаар дотоодынхоо хуультай нийцсэн зохих арга хэмжээ авна. Хэрэв оролцогч улсууд олон улсын байгууллагад нууцын зэрэглэлтэй мэдээлэл өгвөл ийм мэдээллийн нууцлалыг хамгаалах явдлыг хангах арга хэмжээ авна.

3. Дотоодын хуулийнхаа дагуу тарааж болохгүй, эсхүл холбогдох улсын аюулгүй байдалд буюу цөмийн материалыг биелчлэн хамгаалахад занал учруулж болохуйц ямарваа мэдээллийг өгөхийг энэхүү конвенцийн дагуу оролцогч улсуудаас шаардахгүй.

4. Оролцогч улсууд энэ зүйлд дурдсан мэдээлэл илгээх болон хүлээн авахыг хариуцах өөрсдийн эрх бүхий байгууллага болон холбоо барих албаны талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдээлнэ. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга эрх бүхий байгууллага болон холбоо барих албаны талаархи тийм мэдээллийг оролцогч бүх улс болон Олон улсын атомын энергийн агентлагт мэдэгдэнэ. Тийм байгууллага болон холбоо барих албатай байнга харьцах боломжтой байх ёстой.

8 дугаар зүйл

Энэхүү конвенцийн дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор оролцогч улсууд Олон улсын атомын энергийн агентлагийн холбогдох зөвлөмж болон чиг үүргийг харгалзан цацраг идэвхт материалыг хамгаалах явдлыг хангах зохих арга хэмжээг авах талаар бүхий л хүчин чармайлт гаргана.

9 дүгээр зүйл

1. Оролцогч улс бүр 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийг дараахь байдлаар үйлдсэн бол

хэргийн харьяаллаа тогтооход шаардлагатай байж болох арга хэмжээг авна:

(а) тухайн улсын нутаг дэвсгэрт үйлдсэн, эсхүл

(b) гэмт хэргийг үйлдэх үед тухайн улсын төрийн далбааг мандуулсан хөлөг онгоцны тавцан дээр буюу тухайн улсын хуулийн дагуу бүртгэгдсэн агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн, эсхүл

(с) тухайн улсын харьяат үйлдсэн.

2. Оролцогч улс аливаа ийм гэмт хэргийг дараахь байдлаар үйлдсэн бол хэргийн харьяаллаа мөн тогтоож болно:

(а) тухайн улсын харьяатын эсрэг үйлдсэн, эсхүл

(b) тухайн улсын төрийн буюу засгийн газрын хилийн чанд дахь объект, түүний дотор тухайн улсын элчин сайдын яам, эсхүл дипломат буюу консулын төлөөлөгчийн газрын байрны эсрэг үйлдсэн, эсхүл

(с) тухайн улсын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг харьяалалгүй этгээд үйлдсэн, эсхүл

(d) тухайн улсыг ямар нэг үйлдэл хийх, эсхүл хийхгүй байхыг тулган шаардах оролдлогын дагуу үйлдсэн, эсхүл

(e) тухайн улсын засгийн газрын эзэмшлийн агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн.

3. Энэхүү конвенцийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах буюу нэгдэн ормогц оролцогч улс бүр 2 дахь хэсэгт нийцүүлэн дотоодын хууль тогтоомжийн дагуу тогтоосон хэргийн харьяаллынхаа тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэнэ. Аливаа өөрчлөлт орчин бол оролцогч тухайн улс Ерөнхий нарийн бичгийн даргад нэн даруй мэдэгдэнэ.

4. Оролцогч улс бүр сэжигтэн этгээд нутаг дэвсгэрт нь байгаа бөгөөд 1, 2 дахь хэсгийн дагуу хэргийн харьяаллаа тогтоосон оролцогч улсуудын аль нэгд тухайн этгээдийг шилжүүлэн өгдөггүй тохиолдолд 2 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт хэргийн харьяаллаа тогтооход шаардлагатай байж болох арга хэмжээг мөн адилаар авна.

5. Энэхүү конвенц нь оролцогч улсын дотоодын хуульдаа нийцүүлэн тогтоосон эрүүгийн хэргийн аливаа харьяаллыг хэрэгжүүлэх явдлыг үгүйсгэхгүй.

10 дугаар зүйл

1. 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийг үйлдсэн, эсхүл үйлдсэн гэж сэжиглэгдсэн этгээд нутаг дэвсгэрт нь байж болох тухай мэдээллийг хүлээн авмагцаа тухайн оролцогч улс мэдээлэлд байгаа үйл баримтыг мөрдөн шалгахад дотоодын хуулийнхаа дагуу шаардлагатай байж болох арга хэмжээг авна.

2. Нөхцөл байдал тийнхүү шаардаж байгаа гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн, эсхүл гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэгдсэн этгээд нутаг дэвсгэрт нь байгаа оролцогч улс нь тухайн этгээдийг мөрдөх, эсхүл шилжүүлэн өгөх зорилгоор байлгах явдлыг хангах талаар дотоодын хуулийнхаа дагуу зохиох арга хэмжээг авна.

3. 2 дахь хэсэгт дурдсан арга хэмжээг авагдсан аливаа этгээд дараахь эрхийг эдэлнэ:

(а) тухайн этгээд харьяат нь болох буюу тухайн этгээдийн эрхийг өөрөөр хамгаалах эрхтэй улсын, эсхүл хэрэв тухайн этгээд нь харьяалалгүй этгээд бол тухайн этгээд нутаг дэвсгэрт нь байнга оршин суудаг улсын хамгийн ойр байгаа зохиох төлөөлөгчтэй сааталгүйгээр холбоо барих;

(b) тухайн улсын төлөөлөгчтэй уулзах;

(с) (а) болон (b) дэд хэсгийн дагуу эдлэх эрхийнхээ талаар мэдээлэл авах.

4. 3 дахь хэсэгт дурдсан эрхийг гэмт этгээд, эсхүл сэжигтэн этгээд нутаг дэвсгэрт нь байгаа улсын хууль, журамтай нийцүүлэн хэрэгжүүлэх бөгөөд эдгээр хууль, журам нь 3 дахь хэсгийн дагуу эрх олгосон зорилгыг бүрэн хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлсэн байх ёстой.

5. 3, 4 дэх хэсгийн заалт нь 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн (с) дэд хэсэг, эсхүл 2 дахь хэсгийн (с) дэд хэсгийн дагуу хэргийн харьяалал шаардаж буй аливаа оролцогч улс Олон улсын улаан загалмайн хороог сэжигтэн этгээдтэй холбоо бариулах, уулзуулах зорилгоор урих эрхийг хөндөхгүй.

6. Аль нэг оролцогч улс энэ зүйлийн дагуу аливаа этгээдийг саатуулсан тохиолдолд уг этгээдийг саатуулсан тухай болон цагдан хорих үндэслэл болон нөхцөл байдлын тухай 9 дүгээр зүйлийн 1 болон 2 дахь хэсгийн дагуу хэргийн харьяалал тогтоосон оролцогч улсуудад, мөн зүйтэй гэж үзвэл бусад оролцогч сонирхогч улсад шууд, эсхүл Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргаар дамжуулан нэн даруй мэдэгдэнэ. 1 дэх хэсгийн дагуу мөрдөн байцаалт явуулж буй улс олж тогтоосон зүйлийнхээ талаар дээр дурдсан оролцогч улсуудад шуурхай

мэдээлж, хэргийн харьяалал хэрэгжүүлэх чиг санаатай эсэхээ мэдэгдэнэ.

11 дүгээр зүйл

1. Нутаг дэвсгэрт нь сэжигтэн этгээд байгаа тогтоосон оролцогч улс хэрэв тухайн этгээдийг шилжүүлэн өгдөггүй бол 9 дүгээр зүйлийг хэрэглэж байгаа тохиолдолд аливаа онцгой тохиолдолгүйгээр, гэмт хэргийг нутаг дэвсгэрт нь үйлдсэн эсэхээс үл хамааран хэргийг тухайн улсын хуульд нийцсэн ажиллагаа явуулан өөрийн эрх бүхий байгууллагад мөрдүүлэх зорилгоор ямарваа зохисгүй сааталгүйгээр шилжүүлэх үүрэг хүлээнэ. Эрх бүхий тэдгээр байгууллага нь оролцогч тухайн улсын дотоодын хувийн дагуу аливаа бусад ноцтой гэмт хэргийн адил шийдвэр гаргана.

2. Оролцогч улс өөрийн аль нэг харьяатыг шилжүүлэн өгөх буюу өөрөөр өгч, дөв зөвхөн тухайн этгээдийг шилжүүлэх буюу өгөхийг хүссэн шүүх ажиллагаа буюу байцаан шийтгэх ажиллагааны үр дүнд ногдуулсан ялыг эдлүүлэхээр тухайн улсад буцаан өгөх нөхцөлтэйгээр шилжүүлэн өгөхийг дотоодын хуулиар нь зөвшөөрсөн бөгөөд тухайн улс болон уг этгээдийг шилжүүлэн өгөх хүсэлт тавьж буй улс ийм журам болон зохистой гэж үзэж болох бусад нөхцлийг зөвшөөрсөн бол тийм нөхцлөөр шилжүүлэн өгөх буюу өгөх нь 1 дэх хэсэгт заасан үүргийг биелүүлэхэд хангалттай байна.

12 дугаар зүйл

Энэхүү конвенцийн дагуу саатуулагдсан, эсхүл аливаа бусад арга хэмжээ авахуулсан буюу байцаан шийтгэх ажиллагаа явуулсан аливаа этгээдэд шударгаар хандаж, түүний дотор тухайн этгээд нутаг дэвсгэрт нь байгаа улсын хууль болон олон улсын эрх зүйн, түүний дотор хүний эрхийн олон улсын эрх зүйн холбогдох заалтуудад нийцүүлэн бүх эрх, баталгааг эдлэх баталгаа олно.

13 дугаар зүйл

1. Энэхүү конвенц хүчин төгөлдөр болохоос өмнө оролцогч аливаа улсуудын хооронд байгуулсан гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай аливаа гэрээнд 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийг шилжүүлэн өгөх гэмт хэрэгт хамааруулсан гэж үзнэ. Оролцогч улсууд хойшид хоорондоо байгуулах гэрээ бүрт тухайн гэмт хэргийг шилжүүлэн өгөх гэмт хэрэгт хамааруулах үүрэг хүлээнэ.

2. Гэмт этгээдийг гэрээний үндсэн дээр шилжүүлэн өгөх нөхцөл тавьдаг оролцогч улс гэмт этгээд шилжүүлэн өгөх тухай гэрээ байгуулаагүй оролцогч өөр улсаас гэмт этгээд шилжүүлэн өгөх тухай хүсэлт хүлээн авбал хүсэлт хүлээн авагч

оролцогч улс өөрийн үзэмжээр энэхүү конвенцийг 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хувьд гэмт этгээдийг шилжүүлэн өгөх эрх зүйн үндэс гэж үзэж болно. Шилжүүлэн өгөхөд хүсэлт хүлээн авагч улсын хуульд заасан бусад нөхцлийг мөрдөнө.

3. Гэмт этгээдийг гэрээний үндсэн дээр шилжүүлэн өгөх нөхцөл тавьдаггүй оролцогч улсууд 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийг шилжүүлэн өгөх гэмт хэрэг гэж өөр хоорондоо үзэж, хүсэлт хүлээн авагч улсын хуульд заасан бусад нөхцлийг мөрдөнө.

4. Шаардлагатай бол 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийг гарсан газарт нь төдийгүй 9 дүгээр зүйлийн 1 болон 2 дахь хэсгийн дагуу хэргийн харьяаллаа тогтоосон улсын нутаг дэвсгэрт үйлдсэн гэж оролцогч улсуудын хооронд шилжүүлэн өгөх зорилгоор үзнэ.

5. 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хувьд оролцогч улсуудын хоорондын гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай бүх гэрээ, тохиролцооны заалтуудыг энэхүү конвенцид нийцэхгүй байгаа хэмжээгээр өөрчилсөн гэж үзнэ.

14 дүгээр зүйл

1. Оролцогч улсууд 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хувьд мөрдөн байцаалт, эсхүл эрүүгийн байцаан шийтгэх буюу шилжүүлэн өгөх ажиллагаатай холбогдсон туслалцааг өөр хоорондоо дээд зэргээр үзүүлэх, түүний дотор тэдгээр ажиллагаанд шаардлагатай өөрийн мэдэлд байгаа нотлох баримтыг олж авахад нь туслана.

2. Оролцогч улсууд 1 дэх хэсгийн дагуу хүлээсэн үүргээ тэдгээрийн хооронд байгуулсан байж болох эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай аливаа гэрээ буюу бусад тохиролцоотой нийцүүлэн биелүүлнэ. Хэрэв тийм гэрээ буюу тохиролцоо байхгүй бол оролцогч улсууд дотоодын хуулийнхаа дагуу өөр хоорондоо туслалцаа үзүүлнэ.

15 дугаар зүйл

2 дугаар зүйлд заасан аль ч гэмт хэргийг улс төрийн гэмт хэрэг, эсхүл улс төрийн гэмт хэрэгтэй холбоотой гэмт хэрэг, эсхүл улс төрийн сэдэлтээр үйлдсэн гэмт хэрэг гэж шилжүүлэн өгөх буюу эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх зорилгоор үзэхгүй. Иймд улс төрийн гэмт хэрэг, эсхүл улс төрийн гэмт хэрэгтэй холбоотой гэмт хэрэг, эсхүл улс төрийн сэдэлтээр үйлдсэн гэмт хэрэг гэсэн ганц үндэслэлээр тийм гэмт хэрэгт үндэслэсэн шилжүүлэн өгөх буюу эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлтээс татгалзаж болохгүй.

Үндэстний Байгууллагын Төв байранд бүх улс гарын үсэг зурахад нээлттэй байна.

2. Энэхүү конвенцийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, эсхүл батална. Батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, эсхүл батласан тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

3. Энэхүү конвенц аль ч улс нэгдэн ороход нээлттэй байна. Нэгдэн орсон тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

25 дугаар зүйл

1. Энэхүү конвенц нь хорин хоёр дахь батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, батласан буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулсан өдрөөс хойш гуч дахь өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

2. Хорин хоёр дахь батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, батласан буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулсны дараа Конвенцийг соёрхон баталж, хүлээн зөвшөөрч, баталж, түүнд нэгдэн орж буй улс бүрийн хувьд Конвенц тухайн улс батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, батласан буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулсан өдрөөс хойш гуч дахь өдрөөс хүчин төгөлдөр болно.

26 дугаар зүйл

1. Оролцогч улс энэхүү конвенцид нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргаж болно. Санал болгож буй нэмэлт өөрчлөлтийг эх хадгалагчид танилцуулна. Тэрбээр тэдгээрийг оролцогч бүх улсад хүргүүлнэ.

2. Оролцогч улсын олонхи санал болгож буй нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэх бага хурал хуралдуулах хүсэлт гаргах тохиолдолд эх хадгалагч оролцогч бүх улсыг уг бага хуралд оролцохыг урина. Энэ бага хурлыг урилга тарааснаас хойш гурван сараас доошгүй хугацааны дараа явуулна.

3. Бага хурлын оролцогчид нэмэлт өөрчлөлтийг зөвшилцлөөр батлах талаар бололцоотой бүхнийг хийнэ. Хэрэв энэ нь боломжгүй бол нэмэлт өөрчлөлтийг бүх оролцогчийн гуравны хоёрын олонхоор батална. Эх хадгалагч бага хурлаас батласан аливаа нэмэлт өөрчлөлтийг оролцогч бүх улсад шуурхай хүргүүлнэ.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсгийн дагуу оруулсан нэмэлт өөрчлөлт түүнийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, нэгдэн орох, эсхүл батлах тухай баримт бичгийг хадгалуулахаар өгсөн оролцогч улс бүрийн хувьд оролцогч улсуудын гуравны хоёр нь уг баримт бичгийг хадгалуулахаар өгснөөс хойш гуч дахь өдөр хүчин төгөлдөр болно. Түүнээс хойш нэмэлт өөрчлөлт нь оролцогч аливаа улсын хувьд холбогдох баримт бичгийг хадгалуулахаар өгснөөс хойш гуч хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

27 дугаар зүйл

1. Оролцогч аливаа улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад бичгээр мэдэгдэх замаар энэхүү конвенцийг цуцалж болно.

2. Цуцлах тухай мэдэгдлийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга хүлээн авсан өдрөөс хойш нэг жилийн дараа цуцлалт хүчин төгөлдөр болно.

28 дугаар зүйл

Англи, араб, испани, орос, франц, хятад хэлээрх адил хүчинтэй эх бичвэр бүхий энэхүү конвенцийн жинхэнэ эхийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулах бөгөөд Ерөнхий нарийн бичгийн дарга нь түүний баталгаат хуулбарыг бүх улсад илгээнэ.

Дээр дурдсаныг нотолж тус тусын засгийн газраас зохих ёсоор эрх олгогдсон дор гарын үсэг зурагчид 2005 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр Нью-Йорк хотноо гарын үсэг зурахад нээлттэй болсон энэхүү конвенцид гарын үсэг зурцгаав.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар - 12
Төрийн ордон

☎ 265958
Индекс 14003

☎ 329487

Хэвлэлийн хуудас 2